



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 06 сарын 28 өдөр

Дугаар 81

Номгон

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт
ашиглагдаж байгаад актлагдсан барилгыг
иргэн Б.Хатантуулд шилжүүлэх тухай

Баянхонгор сумын иргэн одоогоор тодорхой эрхэлсэн ажилгүй, малын их эмч мэргэжилтэй, магистрант Баттөрийн Хатантуул аймгийн хэмжээнд тулгамдаад байгаа жижиг амьтны мал эмнэлэг /клиник/ байгуулахаар зорьж байгаа бөгөөд орон нутгаас ажлын байр бий болгох хүсэлт ирүүлсэн байна. Ажлын байр бий болгох зорилго нь нийгмийн хөгжлийг дагаад ард иргэд гэрийн тэжээвэр амьтан ихээр тэжээдэг болсон, үүнийгээ дагаад эдгээр амьтдын эрүүл мэндийг хамгаалах ажил орхигдож байгаа, гэрийн тэжээвэр амьтдаас халдварт болон паразит өвчин иргэдэд халдварлах магадлал өндөр байгааг харгалзан Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт агуулахын зориулалтаар 1982 онд ашиглалтанд орсон модон хийц бүхий 10,7x8,5 м хэмжээтэй барилгыг 2017 онд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлаар акталсан бөгөөд одоо төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлгүй хөрөнгийг дэмжлэг болгон шилжүүлэх тухай хэлэлцээд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлаар ТОГТООХ нь:

1. Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт агуулахын зориулалтаар ашиглагдаж байгаад актлагдсан модон хийц бүхий 10,7x8,5 м хэмжээтэй барилгыг иргэн Б.Хатантуулд шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Уг барилгын газрын эзэмшлийг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга /Ж.Баттөр/ нарт үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Г.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР



1190119
D:/2018/Alban bichig/th togtool-2019